

олборлогч орон болсон гэдгээ манай улс дэлхий нийтэд зарлахаар болжээ.

Хүний эрхийн

асуудлаар хэлэлцэх гэнэ

Монгол мэдээ

2010.01.14 №009(2838)

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2006 онд НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг Хүний эрхийн зөвлөл болгон өөрчилж, дэлхийн бүх хүмүүсийн тусын тулд НҮБ-ын гишүүн 192 улсын хүний эрхийн төлөв байдлыг Хүний эрхийн зөвлөлд дөрвөн жил тутам илтгэн хэлэлцүүлж байх шинэ механизм бий болгосон байна.

Монгол улсын Засгийн газар хүний эрхийг хангах, хамгаалах талаар олон улсын болон иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа хэрхэн хэрэгжүүлж байгааг 2010 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүд дүгнэн хэлэлцэх гэж байна. Уг дүгнэлт хэлэлцүүлэгт Монгол Улсын Засгийн газар үндэсний тайлан бэлтгэн оролцохоос гадна Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, төрийн бус байгууллагууд тайлан илтгэл бэлтгэн оруулах боломжтой гэнэ.